

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
10 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-10
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	11-104
	1.“Бүгд Найрамдах Беларусь Улсын нийслэл Минск хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2019.09.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх/	17
	2.“Арабын Нэгдсэн Эмират Улсын нийслэл Абу Даби хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2019.09.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх/	17-31
	3.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир 2018.01.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	31-53
	4.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос Эрчим хүчний сайдад хандан “Сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, чанар, түүнд тавигдах хяналтын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох	53-95
	5.“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	95-96
	6.“Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	96-99
	7.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан/	99-104

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 11-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 38 гишүүн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 28 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: Т.Аюурсайхан, Х.Баделхан, Ж.Бат-Эрдэнэ, Б.Батзориг, Б.Жавхлан, Д.Мурат, Л.Оюун-Эрдэнэ, Г.Солтан, Д.Сумъяабазар, Ч.Улаан, Н.Учрал, Д.Хаянхярваа, С.Чинзориг, Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, С.Жавхлан;

Тасалсан: Ж.Мөнхбат, Б.Наранхүү, О.Содбилэг, Ж.Энхбаяр, Ж.Эрдэнэбат;

Хоцорсон: М.Оюунчимэг -30 минут, Я.Содбаатар -20 минут, Б.Ундармаа -30 минут, Б.Энх-Амгалан -1 цаг 28 минут, С.Эрдэнэ -1 цаг 05 минут.

“Олон улсын охидын өдөр”-т зориулан “Монголын эмэгтэйчүүдийн холбоо”-ноос Улсын Их Хурлын гишүүдэд өгсөн “цэнхэр туулай” болон “урилга”-ыг Улсын Их Хурлын гишүүдийн ширээн дээр байрлуулсан байв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Олон улсын охидын өдөр”-ийг тохиолдуулан охид, эмэгтэйчүүдэд баяр хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Б.Бат-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, Д.Тэрбишдагва, М.Билэгт нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт хэлэлцэх асуудлын 11 дүгээрт орсон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын 3 дугаарт оруулж хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн М.Билэгтийн гаргасан, хэлэлцэх асуудлын 11 дүгээрт орсон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын 3 дугаарт оруулж хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэх асуудлын 3 дугаарт оруулж хэлэлцэхээр тогтов.

.....

Долоо. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх А.Солонго, Ц.Болормаа, референт Б.Золбоо нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Цэрэнбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Болдын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан үг хэлж, санал хураалтад оролцохоос татгалзаж байгаа тухайгаа хуралдаан даргалагчид мэдэгдэв. /18:28/

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	13
Бүгд:	38

65.8 хувийн саналаар хууль батлагдлаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	15
Бүгд:	38

60.5 хувийн саналаар хууль батлагдлаа.

.....

Тэмдэглэлтэй танилцсан:
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
10 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн байгаа тул чуулганыг нээе.

Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Бүгд Найрамдах Беларусь Улсын нийслэл Минск хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

2.Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

3.Өмгөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим бүлэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.

5.Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл.

6.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

7.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

8.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

9.Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал.

10.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан.

11.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд хэлэлцэнэ.

Үдээс хойших хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтоос Эрчим хүчний сайдад хандан сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, чанар, түүнд тавих хяналтын талаар тавьсан асуулгын хариуг сонсоно.

.....

Долоо. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Намсрайн Цэрэнбат танилцуулна. Цэрэнбат гишүүнийг индэрт урьж байна.

Н.Цэрэнбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолын төсөлд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал 2019 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсэгт заасныг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдээр “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл” гэсэн нэр томъёотой холбоотой нийт 26 хэсэг, заалтад холбогдох өөрчлөлт оруулж, Үндсэн хуультай нийцүүлэв. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлүүлэхтэй холбоотой асуудлыг тодруулж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг баталгаажуулахтай холбоотойгоор хугацаа зааж, түүнчлэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийн санал, хураалт явуулах үндэслэлийг тодорхой болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулав. Түүнчлэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхтэй холбоотойгоор Улсын Их Хурлаас батлах хугацааг нь тусгайлан заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмж, хууль хоорондын зөрчлийг арилгасан. Мөн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх шатанд Байнгын хороо болон нам, эвслийн бүлэг саналын түвшинд харгалзан үзсэнээс бусад төсөлд тусгагдаагүй шинэ заалт, саналын томъёолол, санал, дүгнэлтдээ оруулахгүй байх зэрэг нэмэлт, өөрчлөлтүүдийг тус тус боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын Б.Пүрэвдорж асуулт асууж, хариулт авсан болно. Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Д.Тогтохсүрэн нар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлээс “16.2” гэснийг хасах зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Харин төслийн 4 дүгээр зүйлээс “16.3 дахь хэсгийн энэ хуулийн 16.1-д заасны дагуу биечлэн хүргэж танилцуулснаас хойш ажлын 3 өдрийн дотор” гэснийг хасах зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Болд гишүүнээр тасаллаа. Батнасан гишүүнээр тасаллаа. Лувсанвандангийн Болд гишүүн асуулт асууна.

Л.Болд: Тэгэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал одоо бүх нийтийн анхаарлын төвд байгаа. Одоо энэ цаашаа яг аль замаар явах вэ гэдэг дээр хүн болгон гайхаж байгаа байх.

Хоёрдугаар хэлэлцүүлгээр энэ Үндсэн хуульд хамгийн авууштай, хамгийн үнэт зүйл болсон заалт юу вэ гэхээр стратегийн ордуудаа ард түмэн одоо дийлэнх хувийг нь үр ашгийг нь шууд хүртэх энэ чухал заалт орсон юм. Энэ заалтыг хамгаалах ямар нэгэн байдлаар энэ хоёрдугаар хэлэлцүүлгээр маш хүнд нөхцөлд арай хийж дөнгөж яг 57 гишүүнд оролцож байж энэ заалтыг баталсан. Энэ багцыг бол хамгаалах бол хамгийн чухал зүйл байгаа юм. Улсын Их Хурал дахь ШИНЭ намын зөвлөл бол өнгөрсөн хуралдаанаар энэ Үндсэн хуулийн хориг, энэ бусад асуудлыг хэлэлцээд ямар шийдвэр гаргасан бэ гэхээр одоо бол хоригийг хүлээж авахдаа Ерөнхийлөгч хуульж гэж бичсэн байхад энэ тогтоол хэлбэрээр баталсан нь буруу байна. Тийм учраас өнөөдөр бол энэ хуулиа нийцүүлэх эргээд энэ дараа нь цэц болон бусад.../үг тасрав/

Г.Занданшатар: Тэрбишдагва гишүүн одоо санал хураалттай шүү.

Л.Болд: Ямар нэгэн эргэлзээ гарахгүй байх энэ нөхцөлийг хангах ёстой гэсэн ийм хориг байсан. Тийм учраас бидэнд өнөөдөр энэ хоригийг хүлээж авсантай холбогдуулаад одоо хуулийн төсөл яах вэ, хэлэлцээд явдаг. Энэ гурав дахь хэлэлцүүлгийн чиглэл рүү явж байгаа намуудын зөвшилцөл ингээд үргэлжилдэг юм байгаа биз. Гэхдээ энэний зэрэгцээ энэ мухардлаа гэхэд хамгийн гол баталгаажуулах асуудал бол бид нар энэ хоёр дахь хэлэлцүүлгээр баталсан энэ багц асуудлаа бол хууль хэлбэрээр баталгаажуулаад, тэгээд дараагийн Улсын Их Хурлын сонгууль буюу ирэх 6 сард ард нийтийн санал асуулгаар энэ баялагтаа эзэн болох ард түмний баярт мөчийг ойртуулсан ийм санал асуулга болгож хувирах ёстой. Энд бол нэмэгдэл зардал гарахгүй. Ийм бололцоотой. Тэгэхээр энэ асуудлыг бол Байнгын хороон дээр ярьсан уу? Энэ асуудлыг ирэх 7 хоногт Байнгын хороонд оруулж ирэх үү гэдэг асуудал байгаа.

Дээр нь энэхүү зөвшилцөл түрүүн үргэлжилсэн. Одоо ингээд үргэлжилж байхдаа бол бас хаалганы цаана хийгдээд байх вий. Улсын Их Хурлын одоо 3 дахь

суудалтай нам бол байгаа. Тэгэхээр ШИНЭ намын төлөөлөл энэ бүх хэлэлцүүлэг, зөвшилцөлд орох ёстой. Яагаад вэ гэвэл бид бол энэ талаар ард түмэнд үнэн үгийг, мэдээллийг бол байнга хэлж байх ийм шаардлагатай. Тийм учраас энэ зөвшилцөлд ШИНЭ намын төлөөллийг оролцуулахыг шаардаж байна. Сая Ёс зүйн дэд хорооны асуудал яагаад унасан бэ гэхээр хуульд бол намын бүлэг, зөвлөлүүдийн саналыг авна гэсэн. Гэтэл ШИНЭ намын төлөөлөл байхгүй байгаа. ШИНЭ намын зөвлөлөөс бол санал аваагүй. Тэгэхээр энэ асуудал унасан учраас ирэх 7 хоногт Төрийн байгуулалтын байнгын хороогоор дахин хэлэлцэхийнхээ өмнө тэр хуулийнхаа шаардлагыг хангаж ШИНЭ намын төлөөллийг бас оролцуулах ёстой шүү. Тэгэхээр ингэж байж л өнөөдөр энэ парламент Үндсэн хуулийг батлахдаа дараа нь ямар нэгэн эргэлзээгүй, Улсын Ерөнхийлөгч нь дэмжсэн, Цэц нь дэмжчихсэн, парламентын нам, улс төрийн хүчнүүд дэмжчихсэн ийм нөхцөлд л өнөөдөр яг энэ ард түмэн сэтгэл зүрхээрээ хүлээж авах ийм Үндсэн хууль гарна гэдэг нь ойлгомжтой юм. Тэгэхээр ирэх 7 хоногт тэр хоригийн тавьсан гол шаардлагыг хэрэгжүүлж бас хуулийн төслийг нь бол оруулж ирж хэлэлцэх байх гэж найдаж байна. Энэ талаар одоо зөвшилцөлд бид нар оролцож өөрсдийнхөө саналыг хэлнэ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Болд гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл, ард нийтийн санал асуулга явуулах тогтоол 2-т хориг тавьсан хоёр заалтыг нэг тогтоолоор баталсан байсан. Хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээж авсан.

Хориг хүлээж авснаараа ямар нөхцөл байдал үүсэж байгаа вэ гэхээр, нэгдүгээрт бол хориг хүлээж авсантай холбогдуулаад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульдаа өөрчлөлт оруулаад, үүнтэй холбоотойгоор ард нийтийн санал асуулга явуулах эсвэл гуравдугаар хэлэлцүүлэг батлахыг бол Улсын Их Хурал өөрөө шийднэ. Энэ асуудлыг. Үүний өмнө бол журмын тухай хуулиа бид нар өөрчилж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгч бол Үндсэн хуулийг бариад явчихлаа. Журмын тухай хууль барьсангүй гэсэн хориг тавьсан. Энийг Их Хурал хүлээж авсан. Үндсэн хууль журмын тухай хууль 2 маань хоорондоо зөрчилтэй байсан. Монгол Улсын Их Хурлын 62 гишүүн бол Үндсэн хуулиа барьж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн барьсан. Журмын тухай хуультай тодорхой заалтууд нь зөрчилдөж байсан. Тийм учраас бид нар журмын тухай хуулиа Үндсэн хуульдаа нийцүүлж өөрчлөх асуудлыг өнөөдөр Байнгын хороо оруулж ирж байгаа юм. Ингэх юм бол ямар нэгэн хууль хоорондын зөрчил байхгүй. Монгол Улсын Их Хурал бол хууль зөрчсөн процесс урьд ч явагдаагүй. Цаашдаа ч явагдахгүй байх ийм бололцоо, боломж бүрдэх юм. Үүнтэй холбоотойгоор тэр ард нийтийн санал асуулгаар баталсан, батлах чухал гэж та ярьж байна. Энэ бол зөвшилцлийн ажлын хэсгийн явцад яригдана. Гуравдугаар хэлэлцүүлгээр батлах уу эсвэл ард нийтийн санал асуулгаар батлах уу гэдгийг. Ер нь бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд орсон үлдсэн нийт 53 заалтаас 35 заалт үлдсэн байгаа. Энэ 35 заалт бол бүгдээрээ бас олон нийтийн дунд олон жил хэлэлцүүлэг хийгдэж байсан, олон нийтийн дэмжлэгийг авах ийм заалтууд гэж ойлгож байгаа. Тийм болохоор аль ч тохиолдолд бас дэмжлэг аваад батлагдчих, тухайлбал таны одоо ярьж байгаа Монголчууд баялагтаа эзэн байх энэ заалт батлагдчих болов уу гэж найдаж байгаа.

Зөвшилцлийн ажлын хэсэгт бол ШИНЭ намаас оролцож байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Ардчилсан нам, ШИНЭ нам, Монгол Ардын

намын оролцоотой ажлын зөвшилцлийн ажил явагдаж байгаа. Энэ ажил дээр бол бид нар бас тодорхой ажлуудыг ярьж байгаа. ШИНЭ нам бол оролцож байгаа, цаашдаа ч оролцоод явах байх. Ямар нэгэн байдлаар одоо бас нуугдаж, хуйвалдаж, далдуур зөвшилцөж байгаа зүйл байхгүй. Энэ бүхэн ил тод явж байгаа. Зөвшилцлийн ажлын хэсэг дээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс бол Ерөнхий сайд нь ганцаараа Улсын Их Хурлын гишүүн байя, бусад сайд нар нь давхар дээлгүй, гаднаас сонгогддог байя гэсэн саналыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлдөө нэмж оруулаач гэсэн саналыг тавьж байгаа. Ардчилсан намын зөвлөлөөс бол Монгол Улсын Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог байя. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь одоо Монгол Улсын сонгуулийн тогтолцоо, Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо холимог тогтолцоогоор явдаг байя. Нэг хэсэг нь намын жагсаалтаар сонгогддог байя. Нэг хэсэг нь одоо ард түмнээсээ шууд сонгогддог байя. Ийм холимог тогтолцоогоо оруулж ирээч, Үндсэн хуульдаа.

Гуравдугаарт нь Ерөнхий сайд кабинетаа өөрөө бүрдүүлдэг байя гэсэн 3 саналыг одоо эргэж ярьж гэсэн саналыг тавьж байгаа. Энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн одоо Үндсэн хуультай нийцүүлсэн өөрчлөлт батлагдчих юм бол үүний дараа энэ зөвшилцлийн ажлын хэсэг үргэлжилж хуралдана. Энэ асуудлаа шийдээд цаашаагаа тэгээд ард нийтийн санал асуулга явагдах уу, гурав дахь хэлэлцүүлэгт оруулах уу гэдгээ бол Улсын Их Хурал өөрсдөө шийднэ. Энэ бүхэнд одоо ШИНЭ нам оролцоод явах бололцоо, боломж нээлттэй байгаа. Энд ямар нэгэн байдлаар далд юм явахгүй байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Отгоогийн Батнасан гишүүн асуулт асууна.

О.Батнасан: Баярлалаа. Энэ Үндсэн хуультай холбоотой асуудлыг ийм ирц байгаа үед хэлэлцэнэ гэдэг бол юу л болдоо. Яах вэ, тэр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуулийг засдаг нь бол зөв л дөө. Бид өргөн барихдаа Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт гээд оруулчихсан. Журмын тухай хууль дээр болохоор Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль гээд заачихсан. Тэр хууль гэдэг үгийг л засаж байгаа юм. Энийг бол хүлээн зөвшөөрч байгаа юм.

Монгол Улсын Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа энэ дэгийн тухай хууль дээр асуулт орж байгаа. Жишээлбэл 24^б.2.1 дээр нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах явцад төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл хуралдаан даргалагчаас өгөх юм бол хоёр дахь хэлэлцүүлэг чинь задарна. Нөгөө Ардчилсан намынхны тавиад байгаа 3 асуудал буюу яах вэ, Ерөнхий сайдыг тэр Засгийн газрын, Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдээ томилдог нь бол байж болно. Энэ бол хүлээж авах санал. Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлаас томилохыг чинь ард түмэн зөвшөөрөх юм уу? 108 гишүүнтэй болно гээд байгаа Ардчилсан намын саналыг чинь ард түмэн дэмжих юм уу? Тэгэхээр юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр хоёр дахь хэлэлцүүлэг чинь бол салхи оруулна. Хоёр дахь хэлэлцүүлгийг задалж Ардчилсан намын өгсөн 108 гишүүнтэй болно гэдэг саналыг чинь дахиж хураах нь. Ийм хоёрын хооронд зүйл оруулах шаардлага байгаа юм уу? Хоёр дахь хэлэлцүүлгийн үед одоо батлаад явсан Үндсэн хуульд буруу юм юу байна аа? Жишээ нь Их Хурлын гишүүд өөрсдөдөө холбоотой эрх ашгийн өндөр сонирхолтой ямар заалт оруулж өгсөн юм бэ? Одоо ингээд 39 гишүүн байж байна. Хуулийг 39 гишүүнээр баталъя гэж байгаа. Энэ зүйлийг оруулсан. Баялаг нь ард түмний мэдэлд байна. Баялгийн сан

байгуулъя. Энэ зүйлийг оруулсан. Баялгийн өмчийн дийлэнхийг ард түмэн мэднэ гэдэг заалтыг оруулсан. Тэгэхээр гуравдугаар хэлэлцүүлгээ хийгээд явах юм уу? Ард нийтийн санал асуулга явуулах юм уу гэдэг зүйлээ л ярина уу гэхээс биш хоёрдугаар хэлэлцүүлгийг дахиж задална гэдэг асуудал байж болохгүй л гэж бодож байгаа. Би бол энэ санал хураалтад оролцохгүй гэдгээ хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэлчихсэн үү? Батнасан гишүүн. Асуулт биш, тийм ээ? Хариултгүй юу? Батзандан гишүүн? Хэн карт сугалчихав аа? Задална гэсэн юм огт яригдаагүй байна л даа энэ чинь. Хууль дээр урьдчилж дүгнэлт гарч, батлагдаагүй хуулиар урьдчилж дүгнэлт гаргаж болдоггүй юмаа ямар ч хууль тогтоогч. Саранчимэг гишүүн байсан, орж ирээрэй. Батзандан гишүүн, та орж ирнэ шүү. Ирц хүрэхгүй. Карт сугална ч гэсэн энэ өглөөний ирцээр явна. Цогтсайхан дарга, Тогтохоо дарга аа. Эрдэнэбат дарга, Тогтохсүрэн дарга хоёр, 2 бүлэг, зөвлөлийн дарга нар ирцээ нэмээрэй. Болорчулуун, Даваасүрэн гишүүн 2 орж ир. Асуулга дуусангуут гарсан байна. Болорчулуун, Даваасүрэн, Содбаатар, Дамба-Очир энэ тэр өглөө байсан. Хаачсан бэ? Тогтохоо дарга аа, хүмүүсээ дууд. Оюунхорол гишүүн сугалаад буцаагаад хийгээд ирцээс гарчихсан байна. Санжмятав дарга, Энх-Амгалан дарга, 2 дэд дарга ирц бүрдүүлэх ёстой 2 дэд дарга орж ир. Баатарбилэг, Даваасүрэн сайд нар орж ир. Баделхан, Хаянхярваа. Баделхан сайд гадаад явчихсан. Дэлгэрсайхан өглөө байсан. Наранхүү гишүүн огт үзэгддэггүй. Ер нь бараг. Раднаасэд өглөө байсан. А.Сүхбат, Дамдины Цогтбаатар сайд өглөө асуудал хэлэлцэхэд байж байгаад одоо ингээд алга болчих юм. Содномзундуйн Эрдэнэ гишүүн. Дэд дарга Санжмятавыгаа дууд. Дэд даргыг тэгвэл болиулъя. Ирц бүрдүүлэхгүй юм бол. Тэрбишдагва гишүүнийг Ёс зүйн дэд хороон дарга хажуудаа байгаа гишүүнээ олж ир. Би байхгүй байгаа гишүүдийг дахин нэг шалгая. Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн хайчсан? Батнасан гишүүн сая хэлээд гарсан. Гомпилдоогийн Мөнхцэцэг, Наваан-Юндэнгийн Оюундарь, Янгугийн Содбаатар. 2 дэд дарга, Жадамбын Энхбаяр, Дуламсүрэнгийн Оюунхорол, Жадамбын Бат-Эрдэнэ, Төмөрбаатарын Аюурсайхан, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Цэрэнпилийн Даваасүрэн сайд, Загдхүүгийн Нарантуяа, Бөхчулууны Пүрэвдорж гишүүд. Тэрбишдагва гишүүн ирцэд ороод ирц бүрдэж байна. Ороогүй байна. Би энд хараад хэлж байна. Энхтүвшин дарга суугаарай. Оюунхорол гишүүн орж ир. Ямар аавдаа эрхэлж байгаа охин биш. Оюунхорол гишүүн чуулганы танхимд орж ир. Хүн нь хүрэхгүй байна шүү дээ, энэ чинь. Цэрэнбат сайд орж ир.

Байнгын хорооны саналаар гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд, Цэрэнбат. Тэр нөгөө Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх хуулийн эцсийн найруулгыг сонсохгүй юм уу? Хөөе.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо яасан бэ? Сарангэрэл сайд хаачих нь вэ? Цэрэнбат сайд орж ирлээ. Залуу сайдууд одоо жаахан тогтвор суурьшилтай сууна шүү. Үсрээд гараад явчих юм, нэг юм болохоор.

Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явууллаа. Хуулийн төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад 38 гишүүн оролцож 25 гишүүн дэмжиж, 65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хуулийн төслүүд батлагдлаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул.../үг тасрав/. Дэгийн хууль байхгүй. Хамт явчихсан. Хоёр дахь, за байж байгаарай. Сууж байгаарай. Энхболд дарга сууж байгаарай. Ахиад нэг санал хураалт байгаа юм байна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль бол батлагдсан.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Энхтүвшин дарга аа, бэлдээрэй. Санал хураалт эхэллээ. Гарамжав гишүүн суу.

Санал хураалтад 38 гишүүн, 60.5 хувийн саналаар хууль батлагдлаа. Санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүд батлагдлаа. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Гишүүдэд зарлал байна.

Маргааш буюу 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Мод тарих үндэсний өдөр тул Улсын Их Хурлын гишүүдийг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 11 цагт мод тарих үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг урьж байна. Улсын Их Хурлын Тамгын газар.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ГЭРЭЭТ АЖИЛТАН

Б.БААСАНЖАВ

Б.УРАНЧИМЭГ

Д.ЭНЭБИШ